



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 5/08

Хэрлэнбаян-Улаан тосгон

Н.Мөнхтуяад урамшуулал олгох тухай

Монгол Улсын “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 25 дугаар зүйлийн 25.1, “Төсвийн тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дахь хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус тосгоны эрүүл мэндийн төвийн эрхлэгч Н.Мөнхтуяа нь 2025 оны 1 дүгээр улирлын үр дүнгийн гэрээний биелэлтийг 90%-тай “А” үнэлгээтэй хангасан тул үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 54%-иар бодож олгосугай.

2. Урамшууллын зардлыг цалингийн сангаас олгохыг нягтлан бодогч (Ю.Батбаяр)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (А.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАГЧ



Б.ЭНХЦЭЦЭГ